



ЯПОН, МОНГОЛЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Дугаар 2

Энэ удаагийн дугаар 2009 оны 11 сард хэвлэгдсэн анхны дугаарын үргэлжлэл хоёр дахь дугаар бөгөөд сонины зорилго нь япон, монголын эрдэмтэд хамтран хүрээлэн буй орчны тухай ойлголтыг мэргэжлийн бус хүмүүст ойлгомжтойгоор хүргэх юм.

Монгол орны өргөн уудам нутаг хойд бүсээс үргэлжлэх ой хөвч, хээр тал, говийн экологийн шилжилтийн бүсэд оршдог. Энэ удаагийн тусгай дугаарт “Монгол ба хүрээлэн буй орчин”-ны тухай илтгэлээр дамжуулан монголын хүрээлэн буй орчны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг 6 сэдвээр өгүүлнэ.

Хоккайдо их сургуулийн IFES-GCOE хөтөлбөрийн хүрээнд хүрээлэн буй орчинд тулгараад буй асуудлуудыг мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх замаар шийдвэрлэхээр 2010 оны 7 сард “Монгол дахь хээрийн зуны сургалт”-ийг явуулахаар тогтсон байна.



Монгол дахь хээрийн зуны сургалт

Дэлхийн байгаль орчны тулгамдсан асуудал нь цаг хугацаа шаардсан, өргөн цар хүрээтэй судалгаа шаарддаг. Энэ асуудлыг өндөр түвшний нарийн мэргэжлийн судалгаанаас гадна өргөн олныг хамарч шийдвэрлэх хэрэгтэй.

Бид дэлхийн байгаль орчны тулгамдсан асуудлыг хэлэлцэхийн тулд “нэгдмэл шинжлэх ухаан”, “боловсон хүчин бэлтгэх”-ийг гол хүчин зүйл болгоно. Нэгдмэл шинжлэх ухаан гэдэг нь мэдлэг, техник технологи, үнэлэмжийг хамтад нь авч үзэхээс эхлэнэ. Нийгмийн тогтсон зан заншил, соёлд тулгуурлан бий болсон мэдлэг, техник технологи, үнэлэмжийн нэгдлийг оюун ухаан хэмээдэг. Нэгдмэл шинжлэх ухааны зорилго нь оюун ухааныг судлаж, хамтран эзэмших явдал юм. Энэхүү оюун ухааныг хамтран бүтээхэд нэг талаас “Япон, монголын хүрээлэн буй орчин” семинар, “Япон, монголын хүрээлэн буй орчны тухай” сонин, нөгөө талаас Монгол дахь зуны сургалт хэрэгтэй. Япон, монголын хүрээлэн буй орчин” семинар, “Япон, монголын хүрээлэн буй орчин” сонин нь улс орон, соёл, ажил мэргэжил үл харгалзах хамтын оюун ухаан гэж үзвэл “Монгол дахь зуны сургалт” нь уламжлалд суурилсан хамтын оюун ухаан гэж хэлж болно.

Бидний “одоо”-гийн амьдралыг энэ хэвээр нь хадгалахын тулд хүрээлэн буй орчинтой зэрэгцэн орших амьдралын хэв маягийг бий болгох нь чухал. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд өнгөрсөн, одоо, ирээдүйн т а с р а л т г г ү й үргэлжлэх хамтын оюун ухаан нь суурь болно.



Ишикава Мамори
Хоккайдо их сургууль,
Дэлхийн хүрээлэн буй
орчин судлалын
сургуулийн профессор

HEADLINE

- Тусгай дугаар
“Монгол орон ба хүрээлэн буй орчин”-ны талаарх 6 сэдвээр дамжуулан Монголын хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлыг танилцуулна.
- “Япон, монголын хүрээлэн буй орчны хуралдаан” зохион байгуулна.
Дэлхийн хүрээлэн буй орчны өөрчлөлтийн сөрөг нөлөөтэй тэмцэх. Монгол, японы эрчимжсэн хамтын ажиллагааг дэмжих иргэдэд зориулсан семинар.
“Япон, монголын хүрээлэн буй орчны хуралдаан”-ыг танилцуулна.
- Хоккайдо IFES-GCOE “Монгол дахь хээрийн зуны сургалт”-ыг Монголд зохион байгуулна. “Хүрээлэн буй орчны сургалт, дадлага”-ын тухай танилцуулна.




Тусгай дугаарт: Монгол орны хүрээлэн буй орчны тулгамдсан асуудал, илтгэл

Өргөн уудам нутагтай Монгол орны байгаль нь ус, цаг уур, усны эргэлтийн нилээд нарийн зүй тогтолтой. Монгол орон мөнх цэвдгийн тархалтын өмнөд төгсгөлд байрласан ба энэхүү мөнх цэвдэг нь үзэсгэлэн төгөлдөр байгаль, ундрага ус, голын усыг тэтгэдэг. Гэвч сүүлийн жилүүдэд байгалийн гамшиг /ойн түймэр, зуд/, эдийн засгийн хөгжлийг дагасан хүрээлэн буй орчны бохирдлоос /хууль бусаар ойн мод огтлох, ноолуур, уул уурхайн үйлдвэрлэл/ шалтгаалж ой, хээр талд ноцтой нөлөө үзүүлж байна. Байгаль, нийгмийн өөрчлөлтийг дагаад хүмүүсийн ухамсар мөн өөрчлөгдөж байна. Энэ удаагийн дугаарт Монгол орны хүрээлэн буй орчин болон хүмүүсийн үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтийн тухай эрдэмтдийн үзэл бодол, мөн тухайн эрдэмтдийг танилцуулна. Дараах бсэдвээр дамжуулан 2010 GCOE “Монгол дахь хээрийн зуны сургалт”-ийг тайлбарлана.

Сэдэв 1

Монгол орны мөнх цэвдгийн өөрчлөлт, түүний нөлөө



Цэвдэгийн гэсэлтээс үүссэн газрыг гадарга

Монгол орны хойд бүсэд мөнх цэвдэг байдаг. Мөнх цэвдэг нь хур тунадас газрын гүн рүү шингэн орох явцыг сааруулдаг. Тиймээс мөнх цэвдэгт бүсийн газрын хөрс ихээхэн чийгшилтэй байдаг тул хуурай цаг агаартай хэдий ч ой мод сайн ургадаг. Ийм газрын хөрс нь нягтаршил бага тул элс шорооны нүүдэл хялбархан үүсч газрын гадрагын өөрчлөлт үүсэх нөхцөл бий болдог. Газрын хөрсний усны хөлдөлт нь мөсөн линз хэлбэр үүсгэж эзэлхүүн нэмэгдсэнээр хад чулуун хөрсний эвдрэл, нуранга зэрэг аюулыг үүсгэх явдал ч бий. Мөс ихтэй газарт гэсэлт явагдах үеэр хэсэгчлэн газрын хөрсөнд суулт үүсч хотгор газар үүсэх нь бий. Мөн мөнх цэвдэг нь газрын гүний усны урсгалыг зохицуулж ундарга ус, гол усыг тэтгэдэг. Гэвч цаг агаарын дулаарлаас мөнх цэвдэг гэсэж байгаа тухай яригдаж байна. Монгол орны мөнх цэвдэгийн байдал, түүний өөрчлөлт нь ургамал, газрын гадарга, хөрсний усанд ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг бидний гол судлах сэдэв юм.



Ишикава Мамори
Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургуулийн профессор




Мөнх цэвдэг

Жамбалжав Яакин

Монгол улсын ШУА-ийн, Газарзүйн хүрээлэн, Цэвдэг судлалын лабораторийн эрхлэгч

Сэдэв 2

Монгол орны ойн өнгөрсөн ба одоогийн байдал



Ой модыг огтолсон байдал



Баатарбилэг Начин
Монгол улсын их сургууль, Ой судлалын тэнхимийн эрхлэгч, профессор

Монгол орны ой нь нийт нутаг дэвсгэрийн ойролцоогоор 7% буюу хээр талтай харьцуулахад нилээд бага хувийг эзлэх ба сүүлийн жилүүдэд эрс багасах хандлагатай байна. Монгол орны ой нь голдуу уулархаг нутгаар жигд биш тархан байрласан байдаг. Мөнх цэвдэгтэй хойд зүг рүү харсан налуу хэсэгт ой тархан байрласан байдаг ба өмнө зүг рүү харсан налуу хэсэгт ой байдаггүй. Ой нь хар мод /Larix/, нарс /Pinus/, навчит /Betula/ ойгоос бүрддэг. Сүүлийн жилүүдэд Монгол оронд ойн түймэр ихээр гарч, ой ихээр устаж байна. Хууль бусаар мод огтлох, мал аж ахуйгаас үүдэн ой устах аюулд хүрээд байна. Хүний үйл ажиллагаа нь ойн экологийн системд шууд нөлөөлснөөр хурцадмал байдалд хүргээд байна. Бид монголын ойг тойрсон олон тулгамдсан асуудлыг сэдвээ болгож ойг нөхөн сэргээх экологи, физикийн нөхцөл /физик, химийн шинж чанар өөрчлөгдөх цикл, сэргээгдэх явц/, хүний хүчин зүйлийн нөлөө /хууль бусаар мод огтлох, ойн түймэр/, орон нутгийн иргэдийн ойн ашиглалт зэрэг олон өнцгөөс асуудлыг дэвшүүлнэ.



Дамдинсүрэн Содов
Монгол Улсын их сургууль, Биологи судлалын тэнхимийн эрхлэгч, профессор




Монголын ой



Сэдэв 3

Монгол орны бэлчээрийн газрын ашиглалт, нөхөн сэргээлт



Миязаки Шин

Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургуулийн ассистент профессор

Хээр талын экологийн систем нь нүүдэлчдийн амьдралд чухал үүрэгтэй. Энэхүү хээр талын экологийн системийн нөхөн сэргээгдэх хүч нь хүний зохисгүй үйл ажиллагааны /бэлчээрийн даац хэтрэх, автомашины нөлөө, уул уурхайн олборлолт зэрэг/ нөлөөнд автаад байгаа экологийн системийг хэвээр нь хадгалж үлдэх гол тулгуур болоод байна.

Монгол орны хээр талын газрын гарц нь зуны улиралд унах хур тунадасны хэмжээнээс илүү түүний хувиарлалтнаас ихээхэн хамаарна. Энэ нь хөрсөнд агуулагдах усны хэмжээ нь хур тунадасны хэмжээ болон давтамжаас шалтгаалан өөрчлөгдөх ба хөрсөнд агуулагдах усны хэмжээний их багаас ургац хамаарна. Ялангуяа зуны улиралын эхэн хагас буюу 7-р сар хүртэлх хур тунадасны хэмжээнээс тухайн жилийн газрын гарц шалтгаална.

Зуны цагт гарц муу байвал мал тараг тэвээрэг авч чадахгүй өвөлтэй золгоно. Түүний дараа хаврын их цаснаар газрын хөрсөнд цас хунгарлаж идэш тэжээл олж идэхэд хүндрэлтэй болж мал олноор хорогддог. Мал олноор хорогдох энэ байгалийн үзэгдлийг “зуд” гэж нэрлэдэг. Өмнөх жилүүдэд хэд хэдэн удаа зуд нүүрлэж байсан ба 2000-2002 онуудад дараалан зуд болж байсан. Зуд болоход зөвхөн цаг агаар биш хүний хүчин зүйлүүд мөн нөлөөлнө. Өвс ногооны үндэс газарт үлдсэн эсэх, зун хур тунадас их байхаас бэлчээр дахин сэргэж чадах эсэх нь хамаарна.




Шийрэв-Адъяа Самдан

Монголын малчдад бэлчээрийн байдал, цаашдын чиг хандлагын талаар хангалттай мэдээлэл дамжуулах, отор болон малын идэш тэжээл бэлдэх зэрэг хяналтын системийг бий болгох, урьдчилан нарийвчлан тооцоолох шаардлагатай.

Монгол улсын ШУА-ийн, Газарзүйн хүрээлэн, Газарзүйн мэдээллийн системийн лабораторийн эрхлэгч доктор, профессор

Сэдэв 4

Монгол орны ус, цаг уур, усны эргэлт



Сато Томонари

Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургуулийн ассистент профессор

Монгол орон далайд гарцгүй, далайн төвшнөөс нилээд дээш өргөгдсөн. Японтой харьцуулахад хуурай уур амьсгалтай. Гэвч зун агаар нам даралттай байдаг бөгөөд энэ нь хур тунадас унах шалтгаан болдог. Хур тунадас бууснаар мал шим тэжээл авна. Монгол орон дунд өргөрөгийн эх газарт байрлах ба цаг уурын шинжлэх ухааны үүднээс харвал энэ бүс нутаг нь агаарын нам даралтын гол сувагтай давхардсан байх ба хавраас намар хүртэл үе үе агаарын даралт буурдаг. Нөгөөтэйгүүр өвөл Сибирийн агаарын өндөр даралт Монгол орныг нийтэд нь бүрхэснээр уур амьсгал байнга хүйтэн байдаг.

Монголд улирлын ялгаа тод ажиглагдах ба бүс нутгаас хамааран цаг агаарын нөхцөл олон янз байдаг. Өмнөд хэсэг нь /говь/ Төвдийн өндөрлөг газрын нөлөөгөөр хур тунадас багатай байдаг. Харин хойд хэсэг нь хур тунадас ихтэй, зуны улиралд аянга, мөндөр орсноос үер болох тохиолдол цөөнгүй. Сүүлийн үед цаг агаарын дулаарлын талаар их ярих болсон. Харин Монгол оронд хэрхэн нөлөөлж байна вэ? Хүйтний улиралд агаарын хэм нэмэглэж, цас орох, хайлах магадлал байна. Мөн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой засгийн газар хоорондын мэдэгдэлд /IPCC/ дэлхийн олон бүс нутагт бороо орох байдал улам хүчтэй болно гэж таамаг дэвшүүлэгдсэн. Сүүлийн жилүүдэд Монголд ч мөн ялгаагүй цаг уурын гамшгаас хүний амь эрсдэх, мал хорогдох зэрэг аюулт үзэгдэл гарч байна. Ийм аюулт үзэгдэл харьцангуй богино хугацаанд /хэдхэн цаг орчим/ болоод өнгөрөх явдал элбэг тул дулаарлын нөлөө гэх мэт урт хугацааны цаг агаарын сөрөг өөрчлөлттэй хамааралтай эсэхийг судлахын тулд өндөр давтамжтай ажиглалтыг урт хугацааны турш үргэлжлүүлэн хийх шаардлагатай. Улмаар бүс нутгийн хүний үйл ажиллагааны нөлөөг үл тоомсорлож болохгүй. Жишээ нь цаг агаарын ижил нөхцөлд байгаа хэдий ч байгалийн гамшгийн эсрэг авах арга хэмжээ сул байгаагаас их хохирол амсаж болно. Байгалийн гамшгаас үүдэх хохиролыг багасгахын тулд ус, цаг уурын үзэгдлийг судлахын зэрэгцээ орон нутгийн хөгжлийг дагасан сөрөг үр дагаварыг нухацтай хэлэлцэх хэрэгтэй.



Даваа Гомбо

Ус цаг уурын хүрээлэн, Ус сувгийн судалгааны лабораторийн эрхлэгч



Ганболуудэв Пүрэвжав

Ус цаг уурын хүрээлэн, Урьдчилан мэдээлэх судалгааны лабораторын эрхлэгч



Сэдэв 5

Хүрээлэн буй орчны бохирдол



Монголд сүүлийн жилүүдэд хүрээлэн буй орчны бохирдол хурцадмал болоод байна. 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш гадаад орны тусламж, хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн. Мөн монгол орны голлох үйлдвэрлэлийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн үйлдвэрлэлийн эзлэх хувь огцом өссөн. Монгол зэс, алт, түүхий нефть, молибден, уран, үнэт чулуу гэх мэтийн газар доорх нөөц ихтэй. Өмнөговь аймагт шинэ орд илэрүүлэх төсөл хэрэгжиж, цаашид улам эрчимжих хандлагатай байна.

Нөгөөтэйгүүр уул уурхайн олборлолтын бүсэд уул уурхайн хаягдал уснаас гол, хөрс бохирдох явдал ноцтой зүйл болоод байна. Үүний улмаас энэ бүс нутагт амьдрах малчдын амьдралын экологийн хэм хэмжээ зөрчигдөөд байна.

Өвлийн улиралд Улаанбаатар хотод дулааны цахилгаан станц, автомашин, гэр хорооллоос гарах утааны улмаас агаарт агуулагдах хортой бодисын хэмжээ хүрээлэн буй орчны зөвшөөрөгдөх хэмжээнээс давах болсон. Улаанбаатар хотын агаарын бохирдлоос гадна хүн амын хэт их нягтаршил, дэд бүтцийн байгуулалт хоцорч байгаагаас хогны эвгүй үнэр, бие засах газрын бохир зэрэг газрын гүний бохирдол ч тулгамдсан асуудал болоод байна.

Эдгээр хүрээлэн буй орчны бохирдлын тухайд Монгол улсын засгийн газар хүрээлэн буй орчныг хамгаалах хуулийг боловсруулж, боловсон хүчин бэлтгэх, технологийн дэвшил шаардлагатай байгааг онцлон үзэж байна. Япон орон үүнтэй адил хүрээлэн буй орчны бохирдолтой нүүр тулж байсан ба түүний эсрэг хэрэгжүүлсэн технологийг Монголд хэрэгжүүлэх шаардлагатай.

Япон зэрэг гадаадын олон улсын тусламжийн нэг хэсэг болох монголын хүрээлэн буй орчныг хамгаалахыг дэмжих хөтөлбөр бий бөгөөд цаашид энэ байдал сайжрана гэдэгт итгэлтэй байна.



Миязаки Шин

Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургуулийн ассистент профессор



Сэдэв 6

Малчдын хүрээлэн буй орчны талаарх ойлголт ба нийгэм эдийн засгийн байдал

Хүмүүс бид байгаль дэлхийн ивээл дор амьдардаг. Байгаль дэлхий хүмүүст ач ивээлээ зөвхөн өгөх биш үе үе хүнд хэцүү шалгууруудыг оногдуулж байдаг. Бид байгаль дэлхийн ивээлийг “хэрхэн”



ашиглах, мөн байгалийн бэрхшээлийг “хэрхэн” даван туулах вэ гэдэг хүн төрөлхтөний хувьд нийтлэг асуулт юм. “Хэрхэн” гэдэг үгэнд хариулах оновчтой хариулт одоогоор байхгүй.



Өөрөөр хэлбэл байгальтай зөв харьцах тухайд хууль дүрэм шиг мөрдөх ёстой гарын авлага байхгүй. Нийгмийн чиг хандлага, асуудлын онцлог, цар хүрээнээс нь хамаарч нэг нэгээр нь асуудлыг шийдвэрлэх нь өнөөгийн цорын ганц арга юм.

Мэдээж байгаль судлаачид бага багаар түүний механизмийг олж нээсээр байна. Тэрхүү мэдлэг, техник технологи нь биднийг аврах юм. Гэвч судалгааны амжилт гэдэг нь зөвхөн судалгааны хүрээнд тодорхой бөгөөд гайхалтай мэт харагдах ч бодит амьдралд төгс хэрэгжигдэнэ гэсэн үг биш. Эсрэгээрээ муу үр дүн дагуулах нь ч бий.



Ямашита Тэппэй

Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургууль ассистент профессор

Судалгаа шинжилгээний үр дүнг бодит амьдралд хэрэгжүүлэхэд ийм зүлтэй зайлшгүй тулгарна. Судлаачид Хүрээлэн буй орчны талаарх малчдын мэдлэгийг судлах нь байгалиа түшиж үе дамжин амьдарч ирсэн мэдлэгээс суралцаж, улмаар “Хүрээлэн буй орчны шинжлэх ухаан”-ны салбарт хийж буй чухал алхам болно. Малчид байгаль дэлхийд маш их хүндэтгэлтэй ханддаг. Бас байгалийн өмнө өвдөг сөхрөх явдал ч бий. Бидний нэхэл хатуу хөөцөлдөх шинжлэх ухааныг малчид хэрхэн үнэлж, тэдний үнэлэмжийг хэрхэн шинжлэх ухааны дэвшилд нэвтрүүлэх болон эдгээрийн уялдааг бий болгох нь бидний үүрэг юм.



Энхамгалан Сандаг

Монгол улсын ШУА-ийн, Газарзүйн хүрээлэнгийн судлаач



“Япон, монголын хүрээлэн буй орчин” семинар

“Япон, монголын хүрээлэн буй орчин” сэдэвт анхдугаар семинарт япон, монголын эрдэмтэд оролцож, санал солилцож, шинэлэг санаа дэвшүүлэн гаргана. “Монгол-Япон төв”-ийн бүх нийтийг хамарсан энэхүү сургалт семинарт засгийн газрын холбогдох шийдвэр гаргагч байгууллагын төлөөлөл төдийгүй жирийн иргэд хамрагдах боломжтой. Семинарын илтгэгч болон оролцогчдын үнэтэй санал, дүгнэлтийг чухалчлан үзэх болно. Энэ дугаарт уг семинарын илтгэгчийн намтар, илтгэлийн агууллагын тухай танилцуулна.

“Япон, монголын хүрээлэн буй орчин” семинар явагдах өдөр, товч агууллагын тухай дор танилцуулна.

Хэзээ: 2010 оны 2-р сарын 26-ны өдөр 16:00-18:00

Хаана: “Монгол-Япон төв”-ийн хурлын танхим, УБ хот

Зохион байгуулагч: “Монгол-Япон төв”

Хамтран зохион байгуулагч: Хоккайдо Их Сургууль

Энэ удаагийн семинар нь Хоккайдо их сургуулиас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны танилцуулга, Монгол Улсын ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн захирал академич, доктор профессор Д.Доржготов “Монгол орны байгаль орчин” сэдвээр илтгэл тавьж, оролцогчдын асуулт, хариулт, санал дүгнэлтээр үргэлжилнэ.

“Семинарын хөтөлбөр”

16:00-16:05 “Монгол-Япон төв”-ийн захирал

Морикава нээж үг хэлнэ.

16:05-16:30 Хүрээлэн буй орчны асуудлаар явуулж буй монгол, японы хамтын ажиллагаа, Хоккайдо их сургуулийн IFES-GCOE хөтөлбөр”

Илтгэгч: Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургуулийн ассистент профессор Миязаки Шин

16:30-17:20 “Монгол орны байгаль орчин”

Илтгэгч: Монгол Улсын ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн захирал академич, доктор профессор Д.Доржготов

16:30-17:20 Ерөнхий хэлэлцүүлэг

Хөтөлөгч: Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургуулийн ассистент профессор Ямашита Тэппэй

Илтгэгч: Академич, доктор профессор Д.Доржготов

Монгол Улсын ШУА, Газар зүйн хүрээлэнгийн захирал Академич, доктор профессор Д.Доржготов нь ОХУ-ын Москвагийн их сургууль төгссөн.

Мэргэжил: Хөрс судлал, газар зүйч

Монгол улсын их сургуулийн профессор, Монгол улсын боловсролын их сургуулийн профессор, Хятадын Өвөрмонголын

Өөртөө Засах орны Багшийн их сургуулийн хүндэт профессор бөгөөд Монгол улсын их сургуулийн геоэкологийн орчин судлалын тэнхимийн эрхлэгч, Монгол Улсын ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байна. Монгол орны хөрс судлал, газар зүйн чиглэлээр 200 гаруй шинжлэх ухааны бүтээл туурвисан. Япон, ОХУ, Герман, Польш, Хятад, Өмнөд Солонгос зэрэг олон орны эрдэмтэдтэй хамтран судалгаа шинжилгээ хийж байна. Академич, доктор профессор Д.Доржготов 2009 онд монгол улсын үндэсний атласыг хамтран зохиож нийтийн хүртээл болгосон. Энэ удаагийн семинараар “Монгол орны байгаль орчин” сэдвээр илтгэнэ.



Илтгэлийн товч: Монгол орон газарзүйн байршлын хувьд Сибирийн цэвдэгт хөвч тайгаас Төв Азийн хэт хуурай цөл рүү шилжих өргөн уудам нутгийг эзлэн орших тул, нэг талаар байгаль орчны эрс тэс ялгаа ихтэй, нөгөө талаар байгаль-цаг уурын нөхцөл төдий л таатай биш юм. Түүнээс гадна Монголын нийт нутгийн 80 хувь нь далайн түвшнээс дээш 1000 м буюу түүнээс өндөрт байрлах бөгөөд гадаргын төрх байдал жигд биш, мөсөн оргилтой ян сарьдаг, зэллэн цаварсан уул нурууд, ухаа толгод, зоо шил, уудам тавиу хөндий хотгор, цав хоолой, нүд алдам тал газар хослон байдаг нь байгалийн бүс бүслүүрлэг шинжийг нэлээд ээдрээтэй болгожээ.

Талархаг нутагт өргөрөгийн бүсшил, уулархаг нутагт өндрийн бүсшил тодорхой илэрдэг бол уул нуруудын хоорондох хотос хонхруудад “хотгорын бүсшил” гэмээр өвөрмөц зүй тогтол ажиглагдана. Хотгоруудын хамгийн нам, төв хэсэг нь дулааны улиралд орчин тойрноосоо илүү халж, илүү хуурай байх тул тэр хэсэгт агаарын хуйлраа хөдөлгөөн байн байн идэвхжиж шороон шуурга үүсэх голомт болдог байна.

Монгол оронд хүн амын нутагшил маш сийрэг (хөдөөд 1 ам км талбайд 1 хүн оногддог), бас олон мянган жилийн турш уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсний ачаар байгалийн унаган төрх харьцангуй сайн хадгалагдсан тухай судлаачид тэмдэглэж байв. Гэвч өнөөдөр байдал эрс өөрөөр эргэжээ. Дэлхий дахиныг нөмөрсөн уур амьсгалын дулаарал, цөлжилтийн үйл явц угийн гандуу экосистем давамгайлсан эмзэг байгальтай Монголын нөхцөлд бүр ч хүчтэй өрнөж түгшүүрийн дохио дэлдсээр байна.

Бэлчээрийн доройтол, усны хомсдол, хөрсний алдрал, ойн нөөцийн хорогдол, газрын эвдрэл, шороон шуурганы дэгдэлт, элсний нүүдэл, ургамлын бүрэлдэхүүний чанаргүйдэл, нуур ус ширгэх, агаар ус бохирдох зэрэг байгаль орчныг хямралд хүргэх олон сөрөг үзэгдэл, үйл явц хүний буруу үйлдлийн нөлөөгөөр улам бүр эрчимжсээр байна.

Байгалийн экосистемийг эвдэж сүйтгэх аюултай эдгээр үзэгдэл, үйл явцаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тархалтыг нь зогсоож хязгаарлах, байгаль-экологийн тэнцвэрт байдлыг нөхөн сэргээх талаар сургалт сурталчилгаа, менежмент, үйл ажиллагааны цөөнгүй арга хэмжээ авч байгаа хэдий ч үр дүн нь туйлын чамлалттай байна.

“Цөлжилттэй тэмцэх”, “Бэлчээрийн менежментийг сайжруулах”, “Газрын менежментийг боловсронгуй болгох” “Ногоон хэрэм” гэх мэт олон арван төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн гэх боловч харамсалтай нь нааштай үр дагавар харагдахгүй байна. Энэ нь юуны өмнө цаг хугацааны хүчин зүйлтэй холбоотой нь мэдээж. Гэвч байгаль ашиглалтын нэгдсэн бодлого барьж, түүнд нийцсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, бодит, ажил хэрэгч, тууштай, оновчтой үйл ажиллагаа үгүйлэгдсээр байгааг Монгол орны байгаль нийгмийн байдал бэлхнээ харуулж байна.

Монгол улсын үндэсний атлас





Илтгэгч: Доктор, профессор Миязаки Шин

Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургуулийн ассистент профессор

Доктор, профессор Миязаки Шин нь Цүкүба их сургууль, Хүрээлэн буй орчны шинжлэх ухааны судалгааны сургуулийг байгалийн ухаан судлалаар төгссөн.



Мэргэжил: Ус цаг уурч

Токиогийн их сургууль, Үйлдвэрлэлийн технологийн төв, Үндэсний хүрээлэн буй орчны судалгааны төвд алба хашиж байсан. Одоо Хоккайдо их сургууль, Дэлхийн хүрээлэн буй орчин судлалын сургуулийн /GCOE/ ассистент профессор. Азийн бүс нутгийн хур тунадас, усны ууршилтын хэмжээг ажиглаж, усны эргэлтийн системийг тодорхойлж ирсэн. Магистр оюутан байхдаа анх удаа Монголд ажиглалтаар ирэх боломж тохиож, энэ орны байгаль, хүмүүст их татагдсан. Улмаар Монгол оронд хийсэн хээрийн ажлаар нутаг орныг судлаад зогсохгүй, хүмүүстэй харилцах харилцааг чухалчилж, монгол хэл сурсан. Иргэдийн хүрээлэн буй орчны талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой лекц, семинарыг тогтмол явуулж ирсэн.

Илтгэлийн товч: Монгол орны ой мод, хээр талын хорогдол, ойр ойрхон тохиолдох цаг агаарын аюул, мөнх цэвдэгийн гэсэлт, усны нөөцийн хомсдол зэрэг бүс нутгийн оршин суугчдын амьдралд мэдэгдэхүйц өөрчлөлт үзүүлж буй байгаль орчны өөрчлөлт хурдацтай байна. Эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд эрдэм шинжилгээ судалгааны ажил дээр тулгуурлан бодит нөхцөл байдлыг ойлгохоос гадна өргөн цар хүрээтэй сургалт зохион явуулснаар хүмүүсийн хүрээлэн буй орчны талаарх мэдлэгийг дээшлүүлэх нь зүйтэй юм. Хоккайдо их сургуулийн Глобал СОЕ хөтөлбөр “Нэгдсэн бүс нутгийн хүрээлэн буй орчны шинжлэх ухааны сургалт, судалгааны төв цэгийг байгуулах хөтөлбөр” /IFES-GCOE/ болон Япон, Монголын хүрээлэн буй орчны эрчимжсэн хамтын ажиллагаа нь монголын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Хоккайдо их сургуулийн Доктор, профессор Миязаки Шин энэ удаагийн илтгэлээр дээрх үйл ажиллагааг танилцуулна.



Ойд байрлуулсан цаг уурын ажиглалтын цамхаг



Дулаан, ус, нүүрсхүчлийн давхар ислийн хувиргах хэмжээг тодорхойлогч

Хоккайдо IFES-GCOE

“МОНГОЛ ДАХЬ ХЭЭРИЙН ЗУНЫ СУРГАЛТ”

Хоккайдо IFES-GCOE хөтөлбөр нь хүрээлэн буй орчны салбарт тэргүүлэх боловсон хүчин бэлтгэх зорилгоор “МОНГОЛ ДАХЬ ХЭЭРИЙН ЗУНЫ СУРГАЛТ” нэртэй дараах дадлагыг зохион байгуулна. Дэлгэрэнгүй мэдээллийг вэб хуудаснаас үзнэ үү.

【Хэзээ, хаана】

* 2010 оны 7 сарын 16,17-ны өдөр

Улаанбаатар хотноо танилцуулах лекц

* 2010 оны 7 сарын 18-24-ний өдөр

Хээрийн сургалтын багууд газар бүр хээрийн ажиглалт хийнэ.

* 2010 оны 7 сарын 25, 26-ны өдөр

Улаанбаатар хотноо нэгдсэн хэлэлцүүлэг, тайлан

【Оролцогч】

Олон улсын залуу эрдэмтэд, судлаач оюутнууд

【Зорилго】

Янз бүрийн судалгааны салбарын эрдэмтэд өөрсдийн санал бодлоо солилцож, монгол оронд үүсээд байгаа экологийн системийн гажуудлын талаар ойлгож, харилцан ярилцах боломжийг бүрдүүлнэ.

Вэб хуудас:

<http://ifes-gcoe.geography.mn/index.php?huudas=2010-zuny-surgalt>



Хээрийн зуны сургалтын зурагт хуудас

Цаашдын хөтөлбөр

2010 он 5 сар

“Япон, монголын хүрээлэн буй орчин” сэдэвт анхдугаар семинар

“Япон, монголын хүрээлэн буй орчин” сонины гуравдугаар дугаар

2010 он 7 сар

“Япон, монголын хүрээлэн буй орчны өдөр” сэдэвт өдөрлөг

Хээрийн ажиглалтын зуны сургалт Иргэдэд зориулсан семинар, симпозиум гэх мэт

Сонин эрхлэн гаргасан:

Хоккайдо их сургууль, Хүрээлэн буй орчны шинжлэх ухааны сургууль

“Глобал СОЕ хөтөлбөр”-ийг дэмжих төв

Хаяг: Хоккайдо Саппоро хот Кита 10 дүүрэг ниши 5

И мэйл: gcoe@ees.hokudai.ac.jp

Утас: 011-706-4861,4862

Факс: 011-706-4867

Вэб хуудас: [http:// ifes-gcoe.geography.mn/](http://ifes-gcoe.geography.mn/)